

Хайлт хийх

www.polit.mn www.google.com

Эхлэл

Улс төр

Нийгэм

Эдийн засаг

Энтертайнмент

Сэтгүүлчийн булан

Дэлхийд

Ярилцах цаг

Урлаг, спорт

Шар шулуу

## Өвөрмонголчуудын тэмцлийг цагдаагийн хүчээр даржээ

2015 оны 4 сарын 7

Б.БАРС

БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Найман хошуунд нутгийн иргэдийн тэмцлийг цагдаагийн хүчээр хэрцгийлэн дарсан тухай "Radio Free Asia" агентлагийн мэдээллийг хүргэж байна.



Өвөрмонголын Найман хошууны Даачинтал суурингийн ойролцоо оршдог "Найманы химийн боловсруулах бүс" үйлдвэрийн цогцолбор хорт бодис ихээр ялгаруулж буйг эсэргүүцсэн монголчуудын гурван долоон хоног үргэлжилсэн тэмцлийг зогсоохын тулд өчигдөр хоёр мянга гаруй цагдаа илгээжээ. Нутгийн иргэд "Химийн үйлдвэр хорт бодис ялгаруулдгийг эсэргүүцэж байна!", "Найманы иргэдэд цэнгэг ус, хөх тэнгэрийг буцаан өг!" зэрэг уриа лоозон барин жагсч байсан аж.

АНУ-д байрладаг Өмнөд Монголын хүний эрхийн мэдээллийн төв (SMHRIC) байгууллагаас олны хүртээл болгосон видео бичлэг дээр хамгаалалтын иж бүрэн тоноглолтой цагдаа нар жагсагчид руу дайрах үеэр буун дуу сонсогдоно. Жагсаалыг хүчээр тараах явцад олон арван хүнийг баривчилж, 100 гаруй бэртэж гэмтсэн хүнийг эмнэлэгт хүргэсэн тухай SMHRIC мэдээлж байна.

Safari Power Saver  
Click to Start Flash Plug-inЭнд дарж сонингоо  
захиална уу

### Шинэ мэдээ

- ▶ Рауль Кастро Барак Обамаг шударга хүн гэж үнэлэв  
Өнөөдөр 16 цаг 27 минут
- ▶ 80 хувийн хөнгөлөлтэй үнээр техник олгож эхэлжээ  
Өнөөдөр 16 цаг 18 минут
- ▶ Капитолийн ордны ойролцоо буудалцаан болжээ  
Өнөөдөр 16 цаг 4 минут
- ▶ Казиногийн хуулийн ажлыг хэсэгт хэн хэн багтав  
Өнөөдөр 14 цаг 16 минут
- ▶ Жастин Тимберлейк, Жессика Бил нар хүүтэй боллоо  
Өнөөдөр 14 цаг 14 минут
- ▶ Хөдөлмөрийн сайд хуулийн төсөл өргөн барилаа  
Өнөөдөр 11 цаг 2 минут
- ▶ 2052 эхэд "Алдарт эх"-ийн одон өгөхөөр болжээ  
Өнөөдөр 10 цаг 17 минут
- ▶ Цагаан давааны хогийн цэг дээрх иргэдийг бүртгэлжүүлжээ  
Өнөөдөр 10 цаг 12 минут
- ▶ Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тоог 63 байхаар тогтоолоо  
Өнөөдөр 9 цаг 53 минут
- ▶ Цасан болон шороон шүүрганаас

Нэрээ хэлэхээс татгалзсан нэгэн нутгийн иргэн манай сурвалжлагчид ярихдаа, “Ойр орчмын мянга гаруй хүн химийн үйлдвэр рүү түүхий эд зөөвөрлөдөг машинуудыг зогсоохыг оролдсон. Тэгтэл цахилгаан бороотой цагдаа нар гал сөнөөгчдийн хамт иргэд рүү довтлон хайр найргүй зодож цохиж эхэлсэн юм. Өчигдөр өглөө энд хоёр мянга гаруй цагдаа ирсэн билээ. 170 гаруй хүн бэртэж гэмтсэний дээр 70 гаруй хүний баривчиллаа. Тэднийг одоо болтол суллаагүй байна. Цагдаа нар түүнчлэн жагсагчид руу резинэн сумаар буудаж олон хүнийг шархдуулсан. Мөн нулимс асгаруулагч хий ч ашигласан” гэжээ.

Үйлдвэрээс нэг километр зайд оршдог өөр нэг суурингийн оршин суугч хэлэхдээ, зөвхөн тэр суурингаас гэхэд л 20 орчим хүнийг баривчлан авч явжээ. Эсэргүүцлийн тэмцэлд Даачинталаас гадна зэргэлдээ хэд хэдэн суурингийн оршин суугчид оролцсон байна.

Найман хошууны засаг захиргаатай өчигдөр утсаар холбогдоход нэгэн албан тушаалтан “Зөрчлийг арилгахын тулд шаардлагатай бүхнийг хийж байна. Манай удирдагчид газар дээр нь очин ажиллаж байгаа. Харин би тийш яваагүй тул дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй” гэсэн юм.

Гэгээ гэдэг нэгэн оршин суугч SMHRIC байгууллагад мэдээлэхдээ, “Жагсагчдын эсрэг резинэн сум, өндөр даралттай усан буу, нулимс асгаруулагч хий зэргийг ашиглалаа. Өчигдөр 100 гаруй хүн шархдаж, 50 хүн баривчлагдсан бөгөөд эмнэлэгт хүргэгдсэн нэг хүн шархаа даалгүй амь насаа алдаад байна.

Ард иргэд химийн үйлдвэрийн ялгаруулдаг хорт бодисын улмаас ихээр өвчлөн жирэмсэн эхчүүд эндэх нь эрс нэмэгдсэн тул арга буюу эсэргүүцэн тэмцэж эхэлсэн юм. Мал үхэх явдал ч газар авч, жимс ногоо хортой тул идэхийн аргагүй болсон. Ер нь тэмцэгч бидний гол зорилт бол бэлчээр нутаг, цэнгэг ус, цэвэр агаараа хамгаалах явдал” гэжээ.

Цагдаа нар “Найманы химийн боловсруулах бүс”-ийг хамгаалалтдаа авч нутгийн иргэдийг нэг дор цуглахыг хорьж байгаа аж. Энд мөн интернэт, гар утасны холбоог таслажээ.


Эх сурвалж: [www.polit.mn](http://www.polit.mn)



## Их уншсан

## Их сэтгэгдэлтэй

- ▶ Залуужуулах 5 дасгалыг өдөр бүр хийснээр гайхалтай үр дүнг мэдэрнэ  
2014 оны 12 сарын 7
- ▶ Ч.Даариймаа: “ Үлэг Гүрвэлийн Төв Музей” БСШУЯ-ны харьяа улсын чанартай музей болохоос биш нийслэлийн өмч биш  
2015 оны 3 сарын 20
- ▶ Бээжин дэхь консулыг эргүүлэн татахаар боллоо  
2015 оны 3 сарын 26
- ▶ Д.Арвины санаачилгаар “Монгол бичгийн өдөр” арга хэмжээ боллоо  
2015 оны 3 сарын 26
- ▶ Нийслэлд 372 сүм бүртгэгдсэн байна  
2015 оны 3 сарын 20
- ▶ Хөрөнгө оруулалтгүйгээс усаа хил хязгаараасаа алдаж байна  
2015 оны 3 сарын 20
- ▶ Цээл сумыг бүрхсэн лицензийн хэргийг анхан шатанд буцаалаа  
2015 оны 3 сарын 20
- ▶ НҮБ-д Монгол Улсын төрийн далбааг анх мандуулсан хүн Д.Цэвэгмид  
2015 оны 3 сарын 26
- ▶ Түймэр унтрааж байсан иргэн амиа алджээ  
2015 оны 3 сарын 26
- ▶ Ханги боомтоор 200 кг зэс нэвтрүүлэхийг завджээ



Энэ мэдээ танд таалагдаж байвал лайк хийгээрэй

Хэвлэх

Илгээх

**Like Share** 17 people like this. Be the first of your friends.

Манай сайт танд таалагдаж байвал LIKE дараарай

**Like** Buryat Mongol, Shagdar Baigaljav and 4,159 others like this.



**Санал болгох:**



"Хөгжим- Дэлгэрэнгүй зурагт түүх" ном мэндэллээ



"ОЛЛОО GPS" шинэ зураглалтайгаар худалдаанд гарлаа



Лондон хотынхон шоколадан Бенедикт Камбербетчийг иджээ



Өвөрмонголд олдсон үлэг гүрвэлийн үеийн Ромео, Жюльетта хоёр

Таны нэр:

Таны сэтгэгдэл бичих хэсэг:

Илгээх

о

gaixaltasi

2015 оны 4 сарын 8

Хариулах

**Зочин**

зөв,хамгийн муу санаатан бол өвөрлөгчид шүү,

2015 оны 4 сарын 8

Хариулах

**Зочин**

huch tentsvergui tulaand uzseer tentseer l mundag

2015 оны 4 сарын 7

Хариулах

**Сонин хачин**



Төгс эр хүнийг хайсан бүсгүй хаана хүрдгийг м



Дэлхийн түүхэн дэх хамгийн өндөр



Шартахгүй, согтохгүй шоудах арга



СКА-чууд гайхалтай эргэн ирэлтийг хийж



Монголын далбаатай хулгайн анчид живсэн




Хятадын хамгийн бохир далайн эрэг



Эх хүний хараал хамгийн хүчтэй байдаг




Хэнтэйчүүдийг бишрүүлсэн буянтын







ЗАРАА ҮНЭГҮЙ ОРУУЛ ТАНЫ ЗАРЫГ 20 ЗАРЫН САЙТ ДЭЭР ДАВХАР ГАРГАНА



Найрамдал Баянголын аманд газар зарна.




Бүх төрлийн цахилгаан хэрэгсэл засна



Монгол дээл захиалгаар чанартай оёно, зарна.



CXD-n Orchlou horoolold buren tavilgatai 3 uruu



Яаралтай хямд зарна



Вакум болконы хаалт хямдарлаа



Өрхийн төсөв орлого зарлагын дэвтэр



Төмөр хийц "Цогц ган" ххк

<a href="#">Эхлэл</a>	<a href="#">Улс төр</a>	<a href="#">Нийгэм</a>	<a href="#">Эдийн засаг</a>	<a href="#">Энтертайнмент</a>	<a href="#">Сэтгүүлчийн булан</a>	<a href="#">Дэлхийд</a>	<a href="#">Ярилцах цаг</a>	<a href="#">Урлаг, спорт</a>	<a href="#">Шар шувуу</a>
-----------------------	-------------------------	------------------------	-----------------------------	-------------------------------	-----------------------------------	-------------------------	-----------------------------	------------------------------	---------------------------

Эхлэл | Бидний тухай | Сурталчилгаа байршуулах | Вэб сайт хийх | Холбоо барих  
 Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Мэдээлэл хуулбарлах хориотой.